



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/342

Булган сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн  
сарын аяны хүрээнд “Контентын уралдаанд”  
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд “Ажлын байранд нийгэм-сэтгэл зүйн эрүүл орчныг бүрдүүлцгээе!” уриан дор “Контентын уралдаан”-ыг зохион байгуулахад 1,015,000 (нэг сая арван таван мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Уралдаанд ирсэн контентын шинэлэг санаа, бүтээлч байдлыг болон утга санаа нь сарын аяны сэдэвтэй нийцсэн байдал зэргийг харгалзан шалгаруулж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010461

Аймгийн Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 07-ны нийгмийн өдрийн  
А.Б.Ч. дугаар захирамжийн хавсралт



КОНТЕНТИЙН УРАЛДААНД ОЛГОХ ШАГНАЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Тэргүүн байр	1	500,000	500,000
2	Өргөмжлөл	1	5,000	5,000
3	Дэд байр	1	300,000	300,000
4	Өргөмжлөл	1	5,000	5,000
5	Гутгаар байр	1	200,000	200,000
6	Өргөмжлөл	1	5,000	5,000
	<b>Нийт дүн</b>			<b>1,015,000</b>

--o00o--